

ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН БҮТЭЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 2

№	Бүтээлийн дугаар, Оролцогч /Байгууллага/	Төслийн дугаар, бүтээлийн нэр	Бүтээлийн товч танилцуулга
1	№35 Д.Наранболд, Б.Мягмар, С.Галбадрах /ТЗДС/-	35-1. Зүтгүүрийн жолоодлогын сургалтын кабинет	Зүтгүүрийн жолоодлогын интерактив, симулятор төхөөрөмжүүд ашиглан зүтгүүрийн бригадыг богино хугацаанд чанартай бэлтгэх, сургалтыг тасралтгүй явуулах тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ. Төмөр замын дээд сургууль дээр илчит тэрэгний жолоодлогын тренажёр угсарч Оюуны өмчийн газраас ашигтай загварын гэрчилгээ авсан байна. Зүтгүүрийн жолоодлогын кабинет байгуулах 40м2 танхим, санхүүжилтэд 936,000,000 төгрөг шаардлагатай.
2	№36 Б.Эрдэнэцэцэг, Н.Отгонсар, Г.Жаргалсайхан /АТҮТ/	36. Цахим техник ашиглалтын дэвтэрийг нэвтрүүлэх төсөл	ЦАХИМ ТАД” гэдэг нь цахим техник ашиглалтын дэвтэр юм. Энэхүү Цахим ТАД нь www.autobox.mn системд суурилан ажиллах юм. Уг системийг ашиглан иргэд 2020 оноос хойш импортоор орж ирсэн бүх тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй мэдээлэл болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийг харах бүрэн боломжтой. Одоо хэрэглэгдэж байгаа хэвлэмэл техник ашиглалтын дэвтэр нь 6,500 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байна. Манай зорилтот зах зээл жилд дунджаар 29,819 ширхэг дэвтрийг жилд хэрэглэж байгаа бөгөөд ойролцоогоор 194 сая төгрөгийн зардлыг гаргаж байна. Тэгвэл “ЦАХИМ ТАД”-ыг ашигласнаар уг зардлыг бууруулах бүрэн боломж бүрдэнэ. “ЦАХИМ ТАД”-ыг хэрэглэснээр аж ахуйн нэгж байгууллагууд хэдэн тээврийн хэрэгсэлтэй байх нь чухал биш бөгөөд жилд программ ашигласны төлбөрт 100,000 төгрөг төлөхөд зардлыг 72,8%-аар бууруулах боломжтой.
3	№49 ЗТХЯ АТБХЗГ	49. Хотын тээврийн хөгжлийн шинэ хандлага ба инновац	Дэлхийн шилдэг инженерүүд шинжлэх ухааны зөгнөлт маягийн нисдэг таксиг бодит болгохоор уралдаж байна. Улаанбаатарын дээгүүр таксийн үйлчилгээ нэвтрүүлэх талаар санаа гаргасан. Энэ чиглэлээр компаниудын технологийн шинэчлэл, шийдлийн талаарх мэдээллийг ирүүлсэн байна

4	№45 Г.Төгсжаргал, Д.Ганчимэг, Ж.Лут, М.Цогтбаатар, С.Төгөлдөр /ТЗДС/	45. Өртөөний хээрийн байгууламжийн утасгүй мэдрэгчтэй хяналтын төхөөрөмж	Энэхүү судалгаа нь өртөөний хээрийн байгууламжийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох өртөөний трансформаторуудын хүчдэлийг орчин үеийн тоног төхөөрөмжүүдийн тусламжтайгаар постноос хянах боломжтой. Кабелийн сүлжээ үнэ өртөг өндөр байдаг учраас дэвшилтэт утасгүй мэдрэгч сүлжээг ашигласан нь техник эдийн засгийн хувьд давуу талтай. Төслийн үр ашгийн тооцоог хийгдсэн.
5	№11, Л.Эрдэнэхүү /МТЗ ТӨХК/	11. Вагон үйлдвэр төсөл	Улсын хэмжээнд шаардлагатай вагоны хэрэгцээ, шаардлагыг тооцож, вагон үйлдвэр байгуулах судалгаа хийгдсэн. Төслийн эдийн засаг, үр ашгийн тооцоог хийсэн байна.
6	№31 Э.Чанцалдулам, /Автотээврийн үндэсний төв ТӨҮГ/	31. МЭРГЭШСЭН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ БОЛОН ШАЛГАЛТ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖ	Энэхүү судалгааны хүрээнд мэргэшсэн жолооч бэлтгэх эрх зүйн орчны хэрэгжилт, сургалтын хөтөлбөр, агуулга, сургалт зохион байгуулж буй байгуулга болон багшид тавигдах шаардлага, шалгалт авах, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгох үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал судлан, чанарын судалгаа хийн тооцоолж сургалтын төлөв байдлыг тодорхойлсны үндсэн дээр төлөвлөлт, зохион байгуулалтын аргыг санал болгон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна. Мэргэшсэн жолооч нарыг олон улсын жишигт нийцсэн сургалтад хамруулах, бэлтгэх асуудлыг Европын холбооны улс орнуудад мөрдөгдөж байгаа стандарт дүрэм журмаас нутагшуулах саналыг дэвшүүлсэн
7	№25 Б.ЕРБУЛАН /АТҮТ/	25. Тоормосны накладка болон резинэн дугуйны үрэлтээс үүсэх тоосонцорыг багасгах, чийгшүүлэх багаж	Энэхүү судалгааны хүрээнд техникийн хяналтын үзлэгийн төвийн тоормосны стэндэнд өдөр тутам маш олон давтамжтайгаар шалгадаг тоормос болон резинэн дугуйнаас үүсэх нарийн ширхэгт тоосонцорыг багасгах, аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга бол дугуй орчим чийгшүүлэгч төхөөрөмжийг суурьлуулж өгөх юм. Энэ төхөөрөмжийг техникийн хяналтын үзлэгийн тоормосны стэнд орчим суулгаж өгсөнөөр тоормосны накладка, резинэн дугуйнаас ялгарах хорт бодисыг чийгшүүлэх зарчмаар саармагжуулах, сийрүүлэх аргаар алга болгох боломжтой.

8	№35 Д.Наранболд, С.Галбадрах, М.Жаргалсайхан /ТЗДС/	35-2. Илчит тэрэгний түлшний нарийн шүүр цэвэрлэх автомат төхөөрөмжийн төсөл	Илчит тэрэгний түлшний бүдүүн шүүрийг цэвэрлэх үйл ажиллагаа нь гар ажиллагаатай байгаа бөгөөд түлшинд агуулагдаж буй шүлтлэг идэмхий шинж чанартай химийн нэгдлүүд нь хүний биед маш хортой учир ажилчдын эрүүл мэнд сөргөөр нөлөөлж байна. Тийм учраас тус ажиллагааг автоматжуулан ажилчдын эрүүл мэндэд анхаарал тавьж, хүний биед үүсэх хор уршгийг багасган, шүүр цэвэрлэх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор автомат ажиллагаатай төхөөрөмжийн зураг төсөл боловсруулж, материалын болон эдийн засгийн тооцоо хийсэн.
9	№19 Б. Ганзориг /АТҮТ СХДТХҮТ/	19. Fulltime–тай Автотээврийн хэрэгслийн дугуйн өнхрүүлэгч	Энэхүү төслийн гол зорилго Техникийн хяналтын үзлэгт хамрагдаж байгаа авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн хяналтын мэдээллийг үнэн бодитой гаргахад хувь нэмэрээ оруулах бөгөөд үүний тулд энэхүү төхөөрөмжийг хийж ТХ-ийн үзлэг хийхэд ашиглах явдал юм. Төслийн хүрээнд төхөөрөмж үйлдвэрлэгчдээс худалдаж авахад гарах зардлыг судалж, төхөөрөмжийг хийхэд гарах зардлын тооцоог хийсэн
10	№32 Ц.Баяржаргал /ЗТХЯ АТБХЗГ/	32. Хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтын парк (<i>Child Traffic Education Park</i>)"-ийг байгуулах	Хүүхдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг мэдлэгийг олгох, авто зам хэрэглэгчийн харьцаа, хандлага, ёс зүйг бага наснаас нь төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой "Хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтын парк (<i>Child Traffic Education Park</i>)"-ийг байгуулах саналыг дэвшүүлсэн.
11	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-6. Цахилгаан үүсгүүрийн вагон угсрах, хэрэглэгч вагоныг өөрчлөн тоноглох	Гадаад зах зээлээс зорчигчийн вагоны кузовыг явах анги, авто тоормос, ниших татах байгууламжийн хамт худалдан авч цахилгаан үүсгүүрийн 1МВт хүчин чадал бүхий 2 вагон угсрах, одоо ашиглагдаж буй зорчигчийн нийт 60 вагоныг дээрх цахилгаан үүсгүүрийн вагонд холбогдон цахилгаан эрчим хүчээр хангагдахаар өөрчлөн тоноглох. Мөн зорчигчийн вагоны хөргөлтийн систем, халаалт зэргийг цахилгаан эрчим хүчээр шийдэх, цаашид зорчигчдыг хэрэглээний цахилгаан эрчим хүчээр хангах, вагонд интернет орчин, интертаймент систем нэвтрүүлэх

12	№28 Ц.Мөнхжаргал/ИНУТ/	28. ДРОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, НАМ ӨНДРИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС НЭМЭЛТ ОРЛОГО ОЛОХ БОЛОМЖ	Нисэгчгүй нисэх биетүүдийг худалдаа үйлчилгээ, агаарын тээврийн үйлчилгээнд өргөнөөр нэвтрүүлэхэд нисэхийн, мэдээлэл холбооны технологи, банк санхүү даатгал, газар улсын бүртгэл, зэрэг салбарууд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх замаар шинэ төрлийн бизнес үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлснээр эдийн засгийг солонгоруулах, дэлхий нийтэд гарч ирээдүйтэй болохоо харуулсан техник технологийн дэвшлийг ашиглан орлого олох, автозамын түгжрэл, осол зөрчлийг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой
13	№24 -О.Нямхүү /ЗТХЯ ХШҮДАГ/	24. Улс, хот хоорондын ачаа тээвэр зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал	Улс хоорондын автотээврийн ачаа тээвэрлэлтэд өнөөдөр тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, автотээврээр хийх автомашиныг чиргүүлийн хамт Европын холбооны улсаас оруулж ирнэ. Үүнд: VOLVO, BENZ, MAN, SCANIA, DAF зэрэг стандартын шаардлага хангасан 20 тн даацтай 1000 ширхэг автомашиныг, эдгээрт таарсан чиргүүлийн хамт (SCHMITZ, KOGEL) үйлвэрлэгч орноос хөнгөлттэй нөхцөлөөр оруулж тээвэрчдэд хүргэх асуудлыг шийдвэрлэх, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг холбосон нэгдсэн платформ ажиллаж эхлэх эрэлт, урьдач нөхцөл бүрдүүлэх
14	№37 Б.Дөлгөөн ИНУТ	37. AVIA – Aviation Museum and Convention Center” Нисэхийн музей, үзэсгэлэн, хурлын төв	Энэхүү төсөлт судалгааны ажлын зорилго нь нисэхийн салбарын орлогын шинэ үүсвэрийг бий болгох ба үүний хүрээнд дараах шинэ санаачилгыг дэвшүүлж байгаа юм. Үүнд: 1. Өнөөгийн нисэхийн музейн үзвэрүүдийг дэвшилтэт технологи (AR and VR technology) – оор орлуулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын хашаанд байрлаж байгаа 27 агаарын хөлгийг музейн дотор байрлуулж, дэвшилтэт технологиудаар үзвэрүүдийг тайлбарладаг байхаар өөрчлөлт хийнэ. 2. Барилгад хурал, чуулган, концерт, үзэсгэлэн зохион байгуулах танхим байгуулах ба талбайг түрээслүүлнэ 3. Нисэхийн бүтээгдэхүүнийг
15	№38 Х.Одхүү /ИНЕГ/	38. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын 2 дахь төв байгуулах төсөл	Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсын агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй, үр ашигтай, тасралтгүй, тогтвортой байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Нэг төвд төвлөрсөн бүтцээс 2 төвд төвлөрсөн бүтцэд шилжсэнээр хүний хүчин зүйл болон тоног төхөөрөмжийн татгалзал үүсэх, системийн техник үйлчилгээ хийх, туршилтын үйл ажиллагааг явуулах үед ямар нэгэн эрсдэлгүй байх боломж бүрдэж олон улсын жишигт нийцнэ

16	№41 Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	41-2. Улаанбаатар хотын хүн амын нягтрал, түгжрэлийг арилгахад тээврийн салбараас авч хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ	Сэргэлэн сум дахь “Чингис хаан” олон улсын нисэх буудалд “Олон улсын тээвэр логистикийн төв”-ийг байгуулснаар багадаа 2 дахин өсөхөөр байгаа болон төрөөс тус аймагт авч хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийг түшиглэн дагавар хотын бүтээн байгуулалтыг хийх саналыг дэвшүүлж байна.
17	№6 Г.Амарбилэг /УБТЗ-н Төв засварын үйлдвэр/	6. Механикжуулсан хогны сав	УБТЗ-ын Төв засварын үйлдвэрээс байгаль орчиныг хамгаалах, бохирдол багасгах, иргэдэд хогоо зохистой хаях зөв дадал суулгах, инженерийн шийдэл гаргаж хүний оролцоог багасгах төсөл боловсруулсан
18	№40 Э.Базаррагчаа /ИНЕГ ХНАА/	40. Блокчейн технологи дээр суурилсан нислэгийн удирдлагын электрон стрип”	“Монгол улсын иргэний нисэхийн байгууллага нислэгийн гүйцэтгэл мэдээллийг цахим хэлбэрт мэдээллийн үнэн зөв аюулгүй хадгалахын тулд Блокчейн технологийн криптрграф шифрлэлтийн алгоритм ашиглан мэдээллийг хадгалсан электрон стрип” хэрэгжүүлж ашигласнаар хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх мөн нислэгийн удирдлагын мэдээллийг мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлгүйгээр хадгалах боломжтой тул энэхүү төслийг боловсруулсан.
19	№47 Н.Батсайхан, Х.Гансүх, Д.Цэцэгмаа /ИНЕГ ИНУТ/	47. Иргэний нисэхийн салбарын ажиллагсдын тэтгэврийн шинэчлэлийг хийх	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, эдийн засгийн эрх чөлөөт өндөр настны тоог олшруулах нь урт хугацаандаа хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж, амьдралын чанарт сайнаар нөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх тул иргэний нисэхийн салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулах хэрэгслийн тоог нэмэгдүүлэх зорилгоор энэхүү төслийг санаачилсан.
20	№1 П.Гантөгс ИНУТ	1-6. Хүнгүй нисэх төхөөрөмжийг хот, суурин газрын шуудан, ачаа хүргэлт болон бусад хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх нь	ИНЕГ-т хүнгүй нисэх төхөөрөмжийг хориглох, хязгаарлах бүсүүдийг тогтоох, ИНД.101-ийн зохицуулалтыг олон нийтэд танилцан сурталчлах зэргээр ажиллаж, хүнгүй нисэх төхөөрөмжийг 2022 – 2023 онд өргөнөөр ашиглах эхлэх.
21	№21 ЗТХТ	21. ШИЛЭН МЯНДАС ПОЛИМЕР ГҮҮРИЙГ (FRPB) МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ	ЗТХТ-өөс FRPB технологийг нэвтрүүлэх төслийг ирүүлсэн бөгөөд уг технологи нь үндсэн бүтээцийн жин бага тул ган эсвэл бетонон гүүртэй харьцуулахад барьж угсрах хугацаа богино, гүүрийн уртын хэмжээг хүссэн хэмжээгээр захиалж урьдчилан цутгах боломжтой бөгөөд хөдөлмөр хөнгөвчилсөн, насжилт урт тул засвар арчлалтын зардал бага, талбай дээр шууд угсарч болдгоороо давуу талтай.

22	№1 П.Гантөгс ИНУТ	1-5. ИНЕГ-ын Сургалтын төвд олон улсын иргэний нисэхийн сургалтуудыг зохион байгуулах нь	ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвийн өнөөгийн техникийн болон хүний нөөцийн суурь түвшинд үндэслэн, шаардлагад нийцэх сайжруулалтыг хийж, дээр дурдсан олон улсын байгууллагууд болон бусад олон улсын байгууллагуудын тэтгэлэгт шаардлагыг хангасан сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулах санал, санаачлагыг гаргасан
23	№7УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-5 Тээшний вагоныг рефрижатор вагон болгон тоноглох	Зорчигчийн вагон депогоос Тээшний вагоныг рефрижатор вагон болгон тоноглох төсөл ирүүлсэн.
24	№10, Б.Оргил, Б.Ариунболд /ИНЕГ-ын ИМУА/	10.GIS-д суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих системийг иргэний нисэхийн салбарт нэвтрүүлэх	Энэхүү системийн зорилго нь Иргэний нисэхийн мэдээллийн үйлчилгээнд ашиглагдаж буй өгөгдөл, мэдээллийг GIS-д суурилсан платформын тусламжтайгаар нэгтгэж, нэг найдвартай эх сурвалж бүхий мэдээллээр иргэний нисэхийн салбарт хийгдэх томоохон төсөл, арга хэмжээ, үйл ажиллагаануудыг төлөвлөх, шинжлэх, хэрэгжүүлэх оновчтой шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжихэд оршино.
25	№18 /АТҮТ БЗЗТТ	18. Явуулын автобусыг үйлчилгээнд нэвтрүүлэх	“Баянзүрх зорчигч тээврийн төв”-өөс Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх Автотээврийн үйл Ү ажиллагааг иргэдэд танилцуулах зорилгоор “Явуулын автобус”-ыг үйлчилгээнд нэвтрүүлэх төсөл боловсруулж ирүүлсэн.
26	№23 Зам, тээврийн хөгжлийн төв	23. НИЙСЛЭЛ ДЭХ ХОЁР ТҮВШНИЙ ТООНОТ ДУГУЙН ЗАМ БОЛОН ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ТӨСӨЛ	ЗТХТ-өөс Улаанбаатар хотыг хөгжүүлэх, түгжрэлийг бууруулах цогц бодлогын хүрээнд дугуйн замын уртыг нэмэгдүүлэхэд сүлжээ замын эхлэл болгож ХОЁР ТҮВШНИЙ ТООНОТ ДУГУЙН ЗАМ БОЛОН ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН төслийн санааг гаргасан
27	№27 Ц.Мөнхжаргал /ИНУТ/	27. ДИРИЖАБЛЬ МОНГОЛД ХЭРЭГТЭЙ ЮУ	Агаарын том орон зайтай Монгол шиг улсад ашиглахад хамгийн ашигтай. Бага зардлаар хол газар ачаа тээш хүргэх боломжтой. Баруун хойноос зүүн урагш чиглэсэн салхины урсгал ихтэй манай улсад Зүүн өмнөд Ази руу бараа ачаа тээвэрлэхэд тун боломжтой. Хил дээр үүсэх гацаа дарамт илт багасан хямд өртгөөр бараа бүтээгдэхүүнээ хүргэх, уудам агаарын орон зайдаа аялал жуулчлал, орон нутгийн тээвэрлэлт хөгжүүлэх бүрэн боломжтой
28	№34 Т.Мөнхцэцэг /ТЗДС	ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД БҮТЦИЙГ ШИНЭЭР БОЛОН ХҮЧЖҮҮЛЭН БАРЬЖ УГСРАХ НОРМ, АРГАЧЛАЛ	Энэхүү төслийн зорилго нь Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан шинэ төмөр замын төслүүд эрчимтэй хэрэгжиж, төмөр замыг шинээр болон хүчжүүлэн барьж, угсрах бүтээн байгуулалтын ажлын эрх зүйн орчинг сайжруулах оршино

29	№35 Б.Мягмар,Д.Наранбол д, М.Бямбасүрэн	35-3. Илчит тэрэгний элс зэхэлтийн зөөврийн төхөөрөмж зохион бүтээж элс зэхэлтийн хугацааг багасгах, ХАБЭА-г хангах	Зүтгүүрийн бригад солилцдог өртөөд дээр элс зэхэлтийн төхөөрөмж байрлуулснаар илчит тэргэнд элс зэхэх хугацаа багасаж, зүтгүүрийн бригадын хөдөлмөрийг хөнгөвчилнө. Мөн элс зэхэх ажилбарын үед үүсэж болох эрсдэлээс хамгаална.Зүтгүүрт элс зэхэх төхөөрөмжийн зураг төсөл боловсруулж, материалын болон эдийн засгийн тооцоо хийсэн.
30	№3. УБТЗ Вагоны аж ахуйн алба	3-3. Монгол Улсад хөдлөх бүрэлдэхүүний хос дугуй угсрах их засвар хийх, түүний үр өгөөж	Хос дугуйг Зүүнхараа ачааны вагон засварын депо ВКМ барьснаар хос дугуйн нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай хос дугуйг түргэн хугацаанд нийлүүлэх боломж бүрдэнэ. Монгол улсад хувийн эзэмшлийн 33 байгууллагын 6000 орчим ачааны вагон байна. Судалгаагаанаас үзэхэд хувийн вагоны одоогийн байдлаар 1200 орчим хос дугуйн ВКМ засвар хийх шаардлага гарч байгаа гэж үзэж байна. Иймээс ойрын 2-3 жийлийн хугацаанд хувийн эзэмшлийн хос дугуйнд их засварын ажлыг гүйцэтгэн ашиг орлогын нэмэгдүүлэн ажиллана. Хувийн эзэмшлийн 1200 орчим хос дугуйнд их засварын ажил гүйцэтгэхэд гарах ашгийн нийт өртөг дунджаар 6 тэрбум 360 сая төгрөг болохоор байна.
31	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-8. Зорчигчийн вагоныг хөгжлийн бэрхшээлтэй иргэний вагон болгон тоноглох	Зорчигчийн вагоныг энэхүү шийдлээр тоноггосноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэргэнцэртэйгээ төмөр замаар хүндрэл чирэгдэлгүй, ая тухтай аялуулах боломжийг 2015 оноос бүрдүүлсэн байна. Энэ талаар төсөл боловсруулж ирүүлсэн
32	№13, Д.Отгончимэг	13-1. ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ	Төмөр замын салбарт хэрэгжүүлэх 7 зорилттой уялдуулан боловсруулж, тогтвортой байдлыг үнэлэх, дараагийн үе шатны зорилтонд мониторинг хийж, тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тохируулга хийх шаардлагыг тодорхойлох санал ирүүлсэн
33	№15 Т.Чинзориг /МИАТ ТӨХК/	15. АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	Хамгийн зардал багатайгаар байгууллага, хувь хүмүүс хэрэгжүүлэх боломжтой арга зам нь “Sharing буюу Хуваалцах” юм. Судалгаанд оролцогчдын 50 хувь суудлын, 19.6 хувь жийп, 6.3 хувь нь гэр бүлийн зориулалттай авто машинаар замын хөдөлгөөнд оролцдог буюу эдгээр авто машинууд нь үйлдвэрлэгчээс 5-8 хүний суудалтайгаар үйлдвэрлэгдсэн, жолоочоос гадна 4-6 хүртэл хүн тээвэрлэх боломжтой байгаа нь дээрх аргыг ашиглах боломжтойг харуулсан.

34	№39 О.Лхагвасүрэн /ЗТХЯ АЗБХЗГ/	39. АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ	Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаж чадахуйц АЗЗА-ын байгууллагыг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлснээр авто зам хэрэглэгчид аюулгүй авто замаар тав тухай зорчих нөхцөл бүрдэнэ. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн байнгын ашиглалтын бэлэн байдлыг авто замын зурвас газарт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагуудад тодорхой урт зааж хариуцуулж төсөвт хэмнэлт үүсгэх.
35	№41 ЗТХЯ ИНБХЗГ	41-1. Төв аймгийн Сэргэлэн сум дахь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг түшиглэн тээвэр логистикийн төв байгуулах	Улаанбаатар хотоос зүүнээс – баруун чиглэсэн зорчигч тээвэр болон ачаа, тээврийн төмөр замыг Төв аймгийн Сэргэлэн сум дахь “Чингис Хаан” олон улсын нисэх буудал хүртэл барьж байгуулах; Төмөр замыг барьж байгуулснаар ачаа тээврийн агаарын хөлгөөр ирсэн ачаа, барааг захиалагч иргэн, аж ахуй нэгжид хямд зардлаар тээвэрлэн хүргэх болон хөрш зэргэлдээх улсуудад тээвэрлэн хүргэх, тараан байршуулах үйлчилгээг үзүүлэх боломж бүрдэх юм.
36	№26 Ц.Мөнхжаргал /ИНУТ/	26. БУЯНТ- УХАА БҮСЭД СУРГАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ОЛОН УЛСЫН КЛАСТЕР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН	Хөшигийн хөндийд Олон улсын шинэ нисэх буудалтай болж Буянт-Ухаа олон улсын нисэх буудлыг түшиглэн байгаа нөөц, боломж давуу талаа ашиглан дэлхийн зах зээлээс нилээд их хэмжээний валютын орлого олох боломжийг судлан үзсэний дүнд “Буянт-Ухаа бүсэд сургалт, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл худалдааны олон улсын кластер байгуулах” төслийн урьдчилсан саналыг боловсруулсан бөгөөд төр засгийн зүгээс дэмжин санхүүжилт гарган эцэслэн боловсруулах, хэрэгжүүлэх санал ирүүлсэн
37	№8 У.Пүрэвжав /Аварга зам ХХК/	8. Монгол орны нөхцөлд тохирох замын хучлагын бүтээц	Монгол орны нөхцөлд хөрсний тооцоот үзүүлэлтүүдийг түүний чийгшилтээс хамааруулан тогтоох аргачлал бий болгож далангийн тогтворт байдлыг тооцох тооцооны үндэслэл болон авто замын хучлагын оновчтой бүтээцийг бий болгох
38	№17 Б.Гантөмөр /ЗТХЯ ХШУДАГ/	17. Оранж пач нэмэлттэй хүйтэн асфальтбетон хольц.	Монгол орны халуун, хүйтэн нөхцөлд туршигдаж судалгаа, шинжилгээгээр баталгаажсан “Оранж пач нэмэлттэй хүйтэн асфальтбетон хольц”-ыг цаашид авто замын засвар, арчлалтын ажилд өргөнөөр нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг Зам, тээврийн хөгжлийн яамнаас санаачлан хэрэгжүүлэх гэсэн саналыг хүргүүлсэн

39	№20 Т.Батжаргал/ИНЕГ/	20. МОНГОЛ УЛСАД ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙН АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЛЭЭГ НЬ НЭВТРҮҮЛСНЭЭР ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ ШИЙДЭХ САНАЛ	Буянт-Ухаа нисэх буудлыг цаашид Улсын нисэхийн болон ЕЗН-ийг хөгжүүлэх зориулалтаар ашиглаж нийслэлийн иргэдийн хувийн агаарын хөлөг, жижиг нисэх онгоц, нисдэг тэргийг байршуулах нэгдсэн зогсоол, харуул хамгаалалт, засвар техник үйлчилгээний бааз, дадлага сургуулалтын төвийн зориулалтаар нийтийн зорилгод ашиглах. Мөн тус нисэх буудлын хамгаалалтын бүсэд байрлах МИАТ ТӨХК-ний Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын өнөөгийн хүрсэн ололт амжилтанд тулгуурлан хүчин чадлыг өргөтгөн жижиг хөнгөн нисэх онгоц угсрах үйлдвэр байгуулж дотоодын хэрэгцээг хангах импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж улмаар гадаад зах зээлд гаргадаг Нисэхийн аж үйлдвэрийн төв болгон хөгжүүлэх
40	№29 Э.Самбуу-Ёндон /МИАТ ТӨХК	29. “Иргэний агаарын тээврийн зорчигч бүртгэлийн систем”	МИАТ компани 2017 оноос билет захиалгийн болон зорчигч бүртгэлийн SITA системийг Amadeus системээр сольсон. Энэ ажлын хүрээнд Улаанбаатар-Хамбумбат чиглэлийн нислэгтээ өөрсдийн хөгжүүлсэн зорчигч бүртгэлийн системээ ашиглах шийдвэр гарсан. МИАТ Компани 2017 оноос програм хөгжүүлэлтийн ажлаа эхэлж 2018 оны 1-р сарын 1ны өдрөөс үйл ажилгаандаа ашиглаж эхэлсэн. 2022 оны 5-р сарын 26-с зорчигч бүртгэлийн системдээ онлайн бүртгэлийн хэсэг шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр зорчигч https://ot.miat.com веб хуудсаар нэвтрэн орж өөрийн суудлыг бүртгүүлэх боломжтой болсон. Энэ нь бүртгэлийн цагийг багасгаж зорчигч бүртгэлийн цэг дээр заавал очиж хүлээх шаардлагагүй болсноороо давуу талтай.
41	№5 Д.Батбаатар /УБТЗ/	5. W30 бэхэлгээг нэвтрүүлэх нь	Уг бетон дэрний CZ төрлийн бэхэлгээг ашиглахад хөдөлмөр зарцуулалт ихтэй, ашиглалтын явцад резин жийрэг, хуванцар булан эвдэрч, гэмтсэнээр ашиглалтын шаардлага хангахгүйгээс солигдож ашиглалтын зардалд нөлөөлөх сөрөг үр дагаварыг арилгах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор CZ бетон дэрний хэвний плат төмрийн бүтэцийг өөрчлөх замаар CZ бэхэлгээг W30 бэхэлгээгээр солих зорилт тавьсан.

42	№12. Л.Энхсүх /МТЗ/	12. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуу байрлах технологийн зориулалт бүхий 35кВ агаарын шугаманд гэмтлийн байрлал тодорхойлох оновчтой системийг нэвтрүүлэх	Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуу байрлах 35 кВ агаарын шугаманд газардлага үүссэн тохиолдолд гэмтлийн байрлал тодорхойлох оновчтой системийг судлан нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна. Энэ шаардлагын үүднээс нэг фазын газардлага гарах үед 35 кВ агаарын шугаманд ИПВЛ маркын индикатор суурилуулах арга ба гэмтээгүй хоёр фазын аль нэгийг «высокоомный резистор» 1 кОм ба коммутаторын тусламжтайгаар газардуулж улмаар «импульсный наложенный» гүйдэл үүсгэн гэмтлийн байрлал тодорхойлох «Energy. Net» шинэ технологийг хооронд нь харьцуулан судалсан болно.
43	№30 Мөнхжаргал /ИНҮТ/	30. Duty free төсөл	Монгол гаралтай бараа, бүтээгдэхүүн ажил, үйлчилгээг олон улсад гаргах нэг арга зам болох “MONGOL DUTY FREE”-г олон улсын аэропортуудад байгуулан эдийн засгийг солонгоруулах, үйлдвэрлэгчдийг дэмжих зорилготой
44	№48 Д.Бат-Эрдэнэ /ИНЕГ ИНҮТ/	48. Иргэний нисэхийн салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоо	Нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн “Агаарын тээврийн аюулгүй байдлын мэдээллийн систем (AVSiS)” буюу аюулгүй байдлын үйл явцыг бүртгэх, дүн шинжилгээ хийх ажиллагааны тогтвортой хэрэгжих нэг үндсэн нөхцөл нь “Иргэний нисэхийн салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бөгөөд хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох
45	№1 Гантөгс ИНҮТ	1-1.Монгол улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэчлэн зохион байгуулалт	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын ачааллыг жигд хуваарилах, нөөц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, техник технологийн оновчтой шийдлээр зохион байгуулах саналыг боловсруулж гаргасан болно
46	№1 П.Гантөгс	1-2.Орон нутгийн зарим нисэх буудлуудын ашиглалт, нислэгийн чиглэлийн өргөжүүлэлт	Нисэх буудлын үйлчилгээний зохион байгуулалттай уялдсан ирээдүйн төлөвлөлт, чиг хандлагыг шаардагдах зурвасын болон агаарын навигацийн тоног төхөөрөмжийн хамтаар цогцоор боловсруулж гаргасан болно. Ингэснээр орон нутгийн нисэх буудалд буух нислэгийн тоог нэмэгдүүлж, ачаа тээврийн зангилаа төвүүдийг бий болгох, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлогуудыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх

47	№3 УБТЗ Вагоны аж ахуйн алба	3-2. Монгол Улсад ачааны вагон угсрах боломж, түүний үр өгөөж	Төмөр замын ачаа тээврийн эрэлт хэрэгцээг өсөн нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай ачааны вагон паркын шинэчлэлтийг дотоодын нөөц болоцоогоо ашиглан Монгол улсдаа угсарсан вагоноор хангах боломж бидэнд байна. УБТЗ ХНН-ийн харъяа Зүүнхараа дахь ачааны вагон засварын депогийн хамт олон 2017 онд Монгол улсад анх удаа 5 ширхэг ачааны вагоныг амжилттай угсарч, одоог хүртэл тээвэрт ашиглаж байна.
48	№44 У.Уранчимэг/ГТХЗНТ/	44. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сургалтын модуль байгуулах судалгааны төсөл	Судалгааны төслийн гол зорилго нь галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сургалтын чанарыг шинэ түвшинд гаргаж, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилготой. Энэхүү судалгааны төсөлд виртуал сургалтын тухай, олон улс болон Монгол улсад төмөр замын боловсон хүчин бэлтгэдэг сургалт, танхим баазын тухай, олон улсад ашиглаж буй сургалтын /виртуал/ симуляторын тухай, зүтгүүрийн машинч, өртөөний жижүүр мэргэжлээр төгссөн суралцагчдын сүүлийн 5 жилийн байдлаар гаргасан судалгаа, шинэ төмөр замд ажилллах ажилчдын тоо, эдийн засгийн тооцоо зэргийг хийсэн болно.
49	№1 Гантөгс ИНУТ	1-3. Агаарын хөлгийн газрын үйлчилгээний зарим арга хэмжээ	Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны газрын үйлчилгээний машин, техникийн суурийг ашиглаж, инженер техникийн ажилтнуудыг Олон улсын агаарын тээврийн байгууллагын (IATA) сургалтанд хамруулж, ажиллах эрхийг авснаар өндөр бус зах зээлийн боломжит үнэ бүхий үйлчилгээг ИНЕГ-аас цогцоор хүргэх боломжтой болох ба эдийн засгийн нэмэлт үр өгөөж гарах юм
50	№46 Г.Түвшинбаяр /ИНЕГ НЖБШНА/	46. МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙН ХЯНАЛТ УДИРДЛАГЫН ЦЭРЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН САНАЛ	ИКАО байгууллагын Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулсан системд тавигдах нийтлэг шаардлага, техник тодорхойлолт 2021 оноос хойш шинээр гарч байгаа энэ үйл явцыг ашиглан Монгол Улсын агаарын навигацийн системийн шаардлагад нийцсэн Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулсан системийн техникийн шаардлага, тодорхойлолтыг шинээр боловсруулах. Ингэхдээ цэрэг иргэний нисэхийн хамтын ажиллагааны шаардлагыг тусгах нь Монгол Улсын холбогдох эрх зүйн баримт бичиг болон олон улсын иргэний нисэхийн ИКАО байгууллагын стратегийн глобал бодлого болон зөвлөмжтэй нийцүүлэх

51	№4 А.Пүрэвбаатар /УБТЗ Вагоны аж ахуйн алба/	4. Өнхрөх гадаргын хэлбэрийг өөрчлөх замаар вагоны хос дугуйн ашиглалтын хугацааг уртасгасан	Ачааны вагоны хос дугуй дэлний зузааныг 30 мм-ээр зорох аргачлал 2015 оноос хэрэгжиж элэгдлийг 30,8 хувиар бууруулж ашиглалтын болон их засвар хоорондын хугацаа 13 орчим жил байсныг 17-18 жил болгож, жил бүр 1-1,2 тэр бум төгрөгийн хэмнэлт гарч байна.
52	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-2. Зорчигчийн вагоны хөргөлт, агааржуулалтын системээр тоноглох	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос Зорчигчийн вагоны хөргөлт, агааржуулалтын системээр тоноглох техникийн шийдэл боловсруулж ирүүлсэн
53		7-3. Зорчигчийн вагоныг вакуум суултуураар тоноглох	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос Зорчигчийн вагоныг вакуум суултуураар тоноглох техникийн шийдэл боловсруулж ирүүлсэн
54	№16 Батзориг ЗТХЯ ТЗДТБХЗГ/	16-2. Ирээдүй хойч үеийн боловсролд бидний оролцоо-Ус	"Ирээдүй хойч үеийн боловсролд бидний оролцоо-Ус" эссэ бичиж, усаа хэмнэх санал, санаачилга эвшүүлсэн
55	№43 Т.Мейрамбек /ГТХЗНТ/	43. Ухаалаг сэлгээний ажлын схем	Бодит цагийн мэдээлэлд тулгуурлан сэлгээний зүтгүүрийн ашиглалтыг нэмэгдүүлэх, вагоны сул зогсолтыг багасгах, өртөөн дэх сэлгээ, олон улсын болон орон нутгийн галт тэрэгний үйл ажиллагааг нэгэн зэрэг үр ашигтай, аюулгүй зохион байгуулах цогц систем хөгжүүлэх, турших, нэвтрүүлэхэд оршино.
56	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-4. Зорчигчийн вагоныг явуулын амбулаторын вагон болгон өөрчлөн тоноглох	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос Зорчигчийн вагоныг явуулын амбулаторын вагон болгон өөрчлөн тоноглох техникийн шийдэл боловсруулж ирүүлсэн
57	№16 Б.Батзориг	16-1. Ногоон хөгжилд оруулах зам, тээврийн салбарын хувь нэмэр	"Ногоон хөгжилд оруулах зам, тээврийн салбарын хувь нэмэр" эссэ бичиж, зам, тээврийн сүлжээний дагуу ногоон зурвас санал, санаачилга дэвшүүлсэн
58	№1 Гантөгс /ИНУТ АНУГ/	1.4 Өнгөрөлтийн нислэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетинг, төлөвлөлтийн нэгжийг бий болгох нь	ИНЕГ болон ИНУТ-ийн бүтэц дэх газар, албанд өнгөрөлтийн нислэгийн бууралтыг сааруулах, шинэ агаарын тээвэрлэгчдийг нэвтрүүлэх боломж нөхцөлийг идэвхтэй бүрдүүлэх, Олон улсын агаарын тээврийн байгууллага (IATA) болон олон улсын агаарын навигацийн үйлчилгээний байгууллага (CANSO) нартай нягт хамтран ажиллах боломж, нөхцөлд чиглэсэн маркетинг, төлөвлөлтийн нэгжийг бий болгох санаа гаргасан

59	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон	7-9. Панорама вагон төсөл	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос Панорама вагон төсөл боловсруулж ирүүлсэн
60	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-1. eControl system-ийг нэвтрүүлэх төсөл	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос eControl system-ийг нэвтрүүлэх төсөл боловсруулж ирүүлсэн
61	№7 УБТЗ-ын Зорчигчийн вагон депо	7-7. Зорчигчийн тасалгаат вагоныг тусгай вагон болгон тоноглох	УБТЗ-ын Зорчигчийн вагон депогоос Зорчигчийн тасалгаат вагоныг тусгай вагон болгон тоноглох техник, шийдэл боловсруулж ирүүлсэн
62	№9, Далайн захиргаа	9. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг ашиглан Монгол Улсын тээвэр логикийн салбарыг хөнгөвчлөх	Далайн захиргаагаас "ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг ашиглан Монгол Улсын тээвэр логикийн салбарыг хөнгөвчлөх" судалгааны тайланг ирүүлсэн
63	№3.УБТЗ Вагоны аж ахуйн алба	3-1. Зүүнхараа дахь ачааны вагон засварын депогийн өргөтгөл шинэчлэл	УБТЗ болон хувийн хэвшлийн вагонуудын тоо нийт 8948 хүрээд байна. Мөн тус вагонуудыг хурдан шуурхай засварлахын тулд Зүүнхараа дахь ачааны вагон засварын депогийн өргөтгөл шинэчлэл хийх
64	№42 Д.Өлзийсайхан Д.Өлзийсайхан	42. Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам"-ын төсөл	Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтыг нэгдсэн бодлого чиглэлээр хангах, олон улсын түвшинд нийцсэн стандарттай болгох, орчин үеийн сургалтын түвшинд сургах мэргэшүүлэх шаардлагыг үндэслэн журмын төслийг боловсруулсан.
65	№2. Б.Түмэнжаргал //УБТЗ ОУТЗТ/	2.Оновчтой замчлалыг зардалд тулгуурлан тодорхойлох судалгаа	Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол-Солонгос хоёр улсын хооронд нүүрс тээвэрлэлтийн зардлын загварт тулгуурлан замчлалыг оновчтой тодорхойлоход оршино.
66	№13, Д.Отгончимэг /МТЗ/	13-2. ОХУ-МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	Энэхүү судалгааны ажлын зорилго нь ОХУ-Монгол улсын хооронд төмөр замын хамтын ажиллагааны хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн харуулахад оршино. Судалгааны хүрээнд ОХУ-ын 2036 он хүртэлх нийгэм, эдийн засгийн хөгжлийн төсөөлөл, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг бичиг баримтуудыг хамруулан гүйцэтгэсэн болно.

67	№14, Далайн захиргаа	14. Далайд гарцгүй Монгол Улсын хуурай боомтын логистикийн сүлжээг боловсронгуй болгох	Далайн захиргаагаас Далайд гарцгүй Монгол Улсын хуурай боомтын логистикийн сүлжээг боловсронгуй болгох судалгааны тайланг ирүүлсэн
68	№33 Т.Мягмарсүрэн /ЗТХЯ-АТБХЗГ/	33. ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ДОТООДЫН ТЭЭВЭРЛЭГЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ, АВТО ЗАМЫН АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	Дамжин өнгөрөх болон улс хоорондын тээврээс санхүүжилт босгож, жолооч нарыг сургах сургалтын төвийг бий болгож бэхжүүлэх, авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах тоног төхөөрөмж худалдан авах боломжийг болгох санал дэвшүүлсэн. Уг оролцогч нь комиссын гишүүнээр ажиллаж байгаа тул уг уралдааны сонгон шалгаруулалтаас нэрээ татсан.
69	№13, Д.Отгончимэг/МТЗ/	13-3. РОССИЙСКО-МОНГОЛЬСКОЕ ЖЕЛЕЗНОДОРОЖНОЕ СОТРУДНИЧЕСТВО, ПОЛИТИКА РАЗВИТИЯ, РЕАЛИЗАЦИЯ И РЕЗУЛЬТАТЫ ПРОГРАММ	Орос-Монголын төмөр замын хамтын ажиллагаа, хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар өгүүлэл орос хэл дээр ирүүлснийг гишүүд үнэлгээ хийгээгүй.
70	№22 ЗТХТ	22. МОНГОЛ УЛСЫН ЗҮҮН БҮСЭД ДЭЛХИЙН ХАМГИЙН УРТ ШУЛУУН ЗАМТАЙ БОЛОХ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ	ЗТХТ-өөс “Зуун дамжин дуурсагдах томоохон бүтээн байгуулалтын оновчтой санал, шилдэг шийдэл”-д ирүүлсэн материалыг “Шинэ техник, технологи, инновацийн бүтээл”-д оруулж гишүүд үнэлгээ хийгээгүй
71	№41 ЗТХЯ ИНБХЗГ	41-3. Орон нутагт бүсчилсэн тээвэр логистикийн төв байгуулах замаар эдийн засаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх	ИНБХЗГ-аас “Зуун дамжин дуурсагдах томоохон бүтээн байгуулалтын оновчтой санал, шилдэг шийдэл”-д ирүүлсэн материалыг “Шинэ техник, технологи, инновацийн бүтээл”-д оруулж гишүүд үнэлгээ хийгээгүй